



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Тоон хуваагдлын талаар судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг газрын удирдлагад энэ оны 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг /Б.Мягмарнаран/-т даалгасугай.

ДАРГА



Н.ЖАДАМБАА

111447

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 12 сарын 21 өдрийн
127 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Б.Мягмарнаран

Тус газрын шинэчлэлийн бодлого төлөвлөлтийн
газрын дарга

Ажлын хэсгийн нарийн бичиг:

Ц.Одхүү

Тус газрын харилцаа холбоо, дэвшилтэт
технологийн ажлын албаны мэргэжилтэн

Ажлын хэсгийн гишүүд:

Д.Батбаяр

Тус газрын төсөл, хөтөлбөрийн хэлтсийн дарга

Г.Чинзориг

Тус газрын мэдээллийн технологи, инновацийн
хэлтсийн дарга


Ч.Болор-Эрдэнэ

Тус газрын мэдээллийн технологи, инновацийн
хэлтсийн мэргэжилтэн

Э.Шижирбаяр

Тус газрын харилцаа холбоо, дэвшилтэт
технологийн ажлын албаны мэргэжилтэн

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 4 сарын 21 өдрийн
127 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Зорилго:

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд асуудал болон гарч буй тоон хуваагдал /Digital divide/ нь манай улсад хэдий хэмжээнд гарч эхэлсэн талаар судалгаа хийж, шалтгааныг тодорхойлон, цаашид хэрхэн сэргийлэх талаар бусад орнуудын туршлагыг судлан өөрийн оронд тохирсон үндсэн чиглэлийг боловсруулах зорилготой.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Тоон хуваагдлын талаар судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсэг нь дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Өнөөгийн байдлаар хот ба орон нутгийн иргэдийн тоон мэдээллийн хүртээмжийн ялгааг судалж, боломжит статистик мэдээллийг боловсруулан дүн шинжилгээ хийх
2. МХХТ-ийг ашигласан төр ба иргэд, бизнес хоорондын харилцааг нэмэгдүүлж тоон хуваагдлаас сэргийлэхийн тулд цаашид хийх ёстой үйл ажиллагааны хүрээг тодорхойлох
3. МХХТ-ийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих замаар тоон хуваагдлыг багасгах боломж байгаа эсэхийг судлах
4. Манай улстай адил байдалтай болон уг асуудлыг даван туулах талаар ахицтай явж буй бусад орны хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар судлах

Хугацаа:

2014 оны 4 сарын 22-ноос 2014 оны 8-р сарын 01-нийг хүртэл

Хүрэх үр дүн:

Тоон хуваагдлын талаар хийгдсэн судалгааг ашиглан, хот ба орон нутгийн иргэдийн тоон мэдээллийн хүртээмжийн ялгааг хэмжиж, цаашид хэрэгжүүлэх үндсэн чиглэлтэй болно.

--ooOoo--